

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тэнгис шишгэдийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2026/217/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Хөвсгөл аймаг
2026 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: teqshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: : ichinkhorlooga@audit.gov.mn

Ахлах аудитор: Х.Энхтуяа
Утас: 89182456 Цахим хаяг: enkhtuyakh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 01/151
танай _____-ны № _____-т

ТЭНГИС ШИШГЭДИЙН
БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ
ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН
ЗАХИРГААНЫ ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.ИДЭРМӨНХ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Тэнгис шишгэдийн байгалийн цогцолборт газрын Хамгаалалтын захиргааны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тэнгис шишгэдийн байгалийн цогцолборт газрын Хамгаалалтын захиргааны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Улаан Тайгын улсын тусгай хамгаалалттай газраас 209,023.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авч бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар авлагатай холбоотой 155.0 мянган төгрөгийн 1 залруулга хийгдэж байгууллагын бүтэц, орон тоо, нягтлан бодох бүртгэл, тайлагнал, төсвийн зарцуулалт, худалдан авах ажиллагаа, байгууллагын дотоод хяналттай холбоотой 14 зөрчил илрүүлж үүнд 4 албан шаардлага, 10 зөвлөмж хүргүүллээ.

Бусад асуудлын хэсэг

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны “Тэнгис-шишгэдийн байгалийн цогцолборт газрын Хамгаалалтын захиргааг байгуулах тухай” А/160 дугаар тушаалаар Тэнгис шишгэдийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа байгуулагдаж 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна.

Тэнгис шишгэдийн байгалийн цогцолборт газрын Хамгаалалтын захиргааны дарга нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдаар батлуулсан 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 86.6 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Дансны код	Дансны нэр, төрөл	1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0.0	107,258,364.65
33	АВЛАГА	0.0	7,999,306.5
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.0	7,581,606.5
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0.0	262,700
33500	Бусад авлага	0.0	155,000
33510	Байгууллагаас авах авлага	0.0	155,000
35	БАРАА МАТЕРИАЛ	0.0	99,259,058.15
35400	Хангамжийн материал	0.0	97,259,058.15
35410	Бичиг хэргийн материал	0.0	1,833,260
35420	Аж ахуйн материал	0.0	12,085,040
35440	Түлш, шатах тослох материал	0.0	4,080,000
35450	Барилгын засварын материал	0.0	246,500
35470	Бусад хангамжийн материал	0.0	79,014,258.15
35600	Мал амьтад	0.0	2,000,000
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0.0	151,752,506.52
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	0.0	151,752,506.52
39200	Биет хөрөнгө	0.0	149,757,506.52
39201	Барилга, байгууламж, орон сууц	0.0	35,061,850
39202	Хуримтлагдсан элэгдэл	0.0	-194,788.05
39203	Авто-тээврийн хэрэгсэл	0.0	126,028,182.39
39204	Хуримтлагдсан элэгдэл	0.0	-72,043,014.2
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	0.0	62,622,845.26
39206	Хуримтлагдсан элэгдэл	0.0	-6,852,022.2
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	0.0	7,266,799.98
39208	Хуримтлагдсан элэгдэл	0.0	-2,811,596.15
39214	Бусад үндсэн хөрөнгө	0.0	1,873,450.12
39215	Хуримтлагдсан элэгдэл	0.0	-1,194,200.63
39300	Биет бус хөрөнгө	0.0	1,995,000
39301	Програм хангамж	0.0	2,100,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	0.0	-105,000
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	0.0	259,010,871.17
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.0	2,795,600
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	2,795,600
41300	Өглөг	0.0	2,795,600

41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.0	2,465,400
41360	Бусад өглөг	0.0	330,200
41361	Байгууллагад төлөх өглөг	0.0	330,200
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	0.0	256,215,271.17
51	Засгийн газрын хувь оролцоо	0.0	256,215,271.17
51200	Хуримтлагдсан үр дүн	0.0	256,215,271.17
51220	Тайлант үеийн үр дүн	0.0	256,215,271.17
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	0.0	259,010,871.17

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	/төгрөгөөр/	
		1. Өмнөх он	2. Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	0.0	1,072,820,009.37
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.0	1,072,820,009.37
120	Нийтлэг татварын бус орлого	0.0	233,562,109.37
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.0	9,276,000
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	9,276,000
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.0	136,162,951.22
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.0	88,123,158.15
122	Тусламжийн орлого	0.0	839,257,900
1221	Хандив тусламж /дотоод/	0.0	839,257,900
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	0.0	839,257,900
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	0.0	839,257,900
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	0.0	816,604,738.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.0	816,604,738.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.0	617,349,612.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.0	476,848,854.94
210101	Үндсэн цалин	0.0	294,023,056.3
210102	Нэмэгдэл	0.0	114,026,521.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.0	51,893,161.74
210104	Урамшуулал	0.0	16,906,115.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.0	48,707,685.89
210201	Тэтгэврийн даатгалын зардал	0.0	32,662,977.46
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	0.0	4,102,241.58
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	0.0	2,228,882.54
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	0.0	1,705,418.43
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	0.0	8,008,165.88

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.0	21,315,119.42
210301	Гэрэл, цахилгаан	0.0	91,619.42
210302	Түлш, халаалт	0.0	21,016,800
210303	Цэвэр, бохир ус	0.0	206,700
2104	Хангамж, бараа материалын зардал	0.0	14,351,640
210401	Бичиг хэрэг	0.0	2,250,680
210402	Тээвэр, шатахуун	0.0	11,379,860
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.0	644,500
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.0	76,600
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.0	35,652,900
210604	Урсгал засвар	0.0	35,652,900
2107	Томилолт, зочны зардал	0.0	3,828,068
210702	Дотоод албан томилолт	0.0	3,828,068
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.0	8,135,200
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.0	4,941,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.0	2,675,000
210807	Газрын төлбөр	0.0	400,000
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.0	119,200
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.0	8,510,144.7
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	0.0	8,510,144.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.0	199,255,125.25
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.0	199,255,125.25
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	199,255,125.25
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	0.0	256,215,271.17
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	0.0	256,215,271.17

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1.1 Засгийн газрын оруулсан капитал	1.2 Дахин үнэлгээний нөөц	1.3 Хуримтлагдсан үр дүн	1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
19	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	256,215,271.17	256,215,271.17
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.0	0.0	256,215,271.17	256,215,271.17

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	0.0	848,533,900
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.0	848,533,900
120	Нийтлэг татварын бус орлого	0.0	9,276,000
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.0	9,276,000
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	9,276,000
122	Тусламжийн орлого	0.0	839,257,900
1221	Хандив тусламж /дотоод/	0.0	839,257,900
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	0.0	839,257,900
122111	Урсгал санхүүжилтийн орлого	0.0	839,257,900
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.0	848,533,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.0	848,533,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.0	649,016,074.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.0	481,430,371.24
210101	Үндсэн цалин	0.0	298,604,572.6
210102	Нэмэгдэл	0.0	114,026,521.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.0	51,893,161.74
210104	Урамшуулал	0.0	16,906,115.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.0	51,707,776.09
210201	Тэтгэврийн даатгалын зардал	0.0	35,663,067.66
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	0.0	4,102,241.58
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	0.0	2,228,882.54
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	0.0	1,705,418.43
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	0.0	8,008,165.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.0	25,265,259.42
210301	Гэрэл, цахилгаан	0.0	91,619.42
210302	Түлш, халаалт	0.0	25,096,800
210303	Цэвэр, бохир ус	0.0	76,840
2104	Хангамж, бараа материалын зардал	0.0	13,338,900
210401	Бичиг хэрэг	0.0	3,779,940
210402	Тээвэр, шатахуун	0.0	8,914,460
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.0	644,500
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.0	53,055,500
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.0	12,287,700
210604	Урсгал засвар	0.0	40,767,800
2107	Томилолт, зочны зардал	0.0	3,828,068
210702	Дотоод албан томилолт	0.0	3,828,068

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.0	20,390,200
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.0	14,941,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.0	4,930,000
210807	Газрын төлбөр	0.0	400,000
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.0	119,200
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.0	199,517,825.25
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.0	199,517,825.25
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	199,517,825.25

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	857,315,000.0	649,016,074.8	208,298,925.3	75.7
12	Татварын бус орлого	857,315,000.0	649,016,074.8	208,298,925.3	75.7
120	Нийтлэг татварын бус орлого	1,000,000.0	9,276,000.0	(8,276,000.0)	927.6
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	1,000,000.0	9,276,000.0	(8,276,000.0)	927.6
122	Тусламжийн орлого	856,315,000.0	639,740,074.8	216,574,925.3	74.7
122005	Төсвөөс санхүүжих	856,315,000.0	639,740,074.8	216,574,925.3	74.7
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	857,315,000.0	649,016,074.8	208,298,925.3	75.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	857,315,000.0	649,016,074.8	208,298,925.3	75.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	857,315,000.0	649,016,074.8	208,298,925.3	75.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	637,864,400.0	481,430,371.2	156,434,028.8	75.5
210101	Үндсэн цалин	339,454,900.0	298,604,572.6	40,850,327.4	88.0
210102	Нэмэгдэл	196,754,600.0	114,026,521.6	82,728,078.4	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,855,800.0	51,893,161.7	-6,037,361.7	113.2
210104	Урамшуулал	55,799,100.0	16,906,115.3	38,892,984.7	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,251,700.0	51,707,776.1	34,543,923.9	59.9
210201	Тэтгэврийн даатгал	58,651,000.0	35,663,067.7	22,987,932.3	60.8
210202	Тэтгэмжийн даатгал	6,900,200.0	4,102,241.6	2,797,958.4	59.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,450,100.0	2,228,882.5	1,221,217.5	64.6
210204	Ажилгүйдлийн даатгал	3,450,100.0	1,705,418.4	1,744,681.6	49.4
210205	Эрүүл мэндийн даатгал	13,800,300.0	8,008,165.9	5,792,134.1	58.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,528,000.0	25,265,259.4	262,740.6	99.0
210301	Гэрэл, цахилгаан	12,369,900.0	91,619.4	12,278,280.6	00.7

210302	Түлш, халаалт	10,000,800.0	25,096,800.0	-15,096,000.0	250.9
210303	Цэвэр, бохир ус	3,157,300.0	76,840.0	3,080,460.0	02.4
2104	Хангамж, бараа материалын зардал	16,158,900.0	13,338,900.0	2,820,000.0	82.5
210401	Бичиг хэрэг	3,780,000.0	3,779,940.0	60.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	8,914,500.0	8,914,460.0	40.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,042,500.0	644,500.0	398,000.0	61.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,440,000.0	00.0	1,440,000.0	-100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	981,900.0	00.0	981,900.0	00.0
2105	Нормативт зардал	2,058,300.0	00.0	2,058,300.0	-100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,058,300.0	00.0	2,058,300.0	-100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	53,055,500.0	53,055,500.0	00.0	100.0
210604	Урсгал засвар	40,767,800.0	40,767,800.0	00.0	100.0
2107	Томилолт, зочны зардал	3,828,100.0	3,828,068.0	32.0	100.0
210702	Дотоод албан томилолт	3,828,100.0	3,828,068.0	32.0	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,570,100.0	20,390,200.0	12,179,900.0	62.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,000,000.0	14,941,000.0	59,000.0	99.6
210803	Даатгалын үйлчилгээ	587,700.0	00.0	587,700.0	00.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	358,400.0	00.0	358,400.0	00.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	370,000.0	00.0	370,000.0	00.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,930,000.0	4,930,000.0	00.0	100.0
210807	Газрын төлбөр	11,189,600.0	400,000.0	10,789,600.0	-96.4
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	134,400.0	119,200.0	15,200.0	-11.3

3. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 55,854.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 155.0 мянган төгрөгний залруулах бичилт хийж, 45,057.2 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 10,642.4 мянган төгрөгийн зөвлөмж өглөө.

3.1 Залруулга

1.Авлагатай холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт

"Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ний дансанд санхүүгийн Acolous программын лицензын эрхийн төлбөр 400.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч тухайн байгууллагатай гэрээ байгуулаагүй тус программыг ашиглаагүй, СИТИЭС компаний СИТИЭС санхүүгийн программыг ашиглаж байна. Цаашид Acolous программыг ашиглахгүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна. Аудитын хугацаанд залруулж ажилласан.

3.2 Төлбөрийн акт:

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно

3.3 Албан шаардлага

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт

Иргэн Р.Зоригттой автомашин /ХӨУ 5846, land cruiser 80 марк/ түрээслэх, түрээслүүлэх гэрээг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр байгуулсан байна. Тус автомашины засварын зардалд 2 удаагийн гүйлгээгээр нийт 2,050.0 мянган төгрөгийг “Хүслэн авто засвар”-ын нэхэмжлэл, зарлагын баримттай байхад автомашин түрээслүүлэгч иргэн Р.Зоригийн дансанд шилжүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргэхээр шийдвэрлэлээ.

2. Ажил хавсран гүйцэтгэсэнтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт

Тэнгис шишигэдийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны даргын 2025 оны өдрийн Б/31 дүгээр тушаалаар архив, бичиг хэрэг, дотоод ажил хариуцсан ажилтан Б.Ариунзаяад тус байгууллагын хүний нөөцийн ажилтны ажлыг хавсран гүйцэтгүүлж 40 хувийн нэмэгдлийг олгосон байна. Хүний нөөцийн ажилтны орон тоо нь Тэнгис шишигэдийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны бүтэц, орон тоонд батлагдаагүй орон тоо байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025.08.25-ны өдрийн А/688 дугаар дугаар тушаалаар батлагдсан "Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаад"-ын бүтэц, орон тооны дээд хязгаар болон сургалт, мэдээллийн төвийн байршлыг шинэчлэн батлах тухай тушаал, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргэхээр шийдвэрлэлээ.

3. Унаа, хоолны хөнгөлөлттэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт

Нягтлан бодогч Г.Баасан нь Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газар болон Тэнгис шишигэдийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа гэсэн 2 байгууллагаас унаа, хоолны хөнгөлөлтийг давхардуулан авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.3 "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргэхээр шийдвэрлэлээ.

4. Гэрээ байгуулахтай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт

Иргэн Ө.Майнбаярын хувийн дансанд принтерийн үнэ 600.0 мянган төгрөг, иргэн Т.Мөнхдалайн хувийн дансанд радио релейны үнэ 2,040.0 мянган төгрөг, "Кибер жаал" ХХК-ний дансанд компьютерийн программ суулгуулсны төлбөр 2,430.0 мянган төгрөг, Нямдаваагийн хувийн дансанд хөрөөний үнэ 300.0 мянган төгрөг нийт 5,370.0 мянган төгрөг гэрээ байгуулаагүй шилжүүлсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйл "Гэрээ шууд байгуулах арга", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргэхээр шийдвэрлэлээ.

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Газар өмчлөлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт

Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн өмчлөлийн газар дээр Тэнгис шишгэдийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны албан конторын барилга барьсан байна. Газрын кадастр 400.0 мянган төгрөгөөр хийлгэсэн, өмчлөлийн асуудал шийдэгдээгүй, гэрчилгээ гараагүй байна. Энэ нь Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 "хүчин төгөлдөр эрхийн гэрчилгээгүй аливаа этгээд газар эзэмшихийг хориглоно" 35 дугаар зүйлийн 35.3.5 "бусдын газар эзэмшихтэй холбогдсон эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх", санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохимжтой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул зөвлөмж хүргэхээр шийдвэрлэлээ.

Өгсөн зөвлөмж:

Газар өмчлөлийн асуудлыг шийдвэрлэх

2. Үлдэгдэл тулган баталгаажуулахтай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт

Худалдах, худалдан авах гэрээ байгуулсан 4 иргэн, аж ахуйн нэгжтэй өр, авлагын тооцоо нийлж үлдэгдлийн баталгааг хийгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана", Санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул зөвлөмж хүргэхээр шийдвэрлэлээ.

Өгсөн зөвлөмж:

Гэрээний биелэлтийг тооцон, үлдэгдлийн тулган баталгаажуулалтыг хийж хэвших

3. Шатахуун зарцуулалтын жишиг нормтой холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт

Түлээ тээвэрлэсэн УАЗ Зил 130 машин нь 100 км-т 50-110 литр шатахуун, түрээсээр ашиглаж байгаа LAND 80 автомашин 100 км-т 50-60 литр шатахуун зарцуулсан байна. Энэ нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар батлагдсан "Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ыг баримтлаагүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул зөвлөмж хүргэхээр шийдвэрлэлээ.

Өгсөн зөвлөмж:

Шатахуун зарцуулалтын жишиг нормыг баримтлах

1. Шатахуун зарцуулалтын тайлан холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт

Шатахууны орлого, зарлагын баримтыг шатахуун олгосон шаардах хуудас, жолоочийн тооцооны хуудастай тулгалт хийхэд 664.1 мянган төгрөгөөр шатахууны орлогыг дутуу авсан, 161.5 мянган төгрөгийн шатахуун зарцуулалтыг дутуу хөтөлсөн зөрчил илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул зөвлөмж хүргэхээр шийдвэрлэлээ.

Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах

5. Зардлын эдийн засгийн ангилалтай холбоотой асуудал

5.1 Илрүүлэлт

Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалал 71405 хөтөлбөрийн зардлын 817030 ургамал хамгааллын зардлаас 10,000.0 мянган төгрөгөөр завь худалдан авсан, 210402 тээвэр шатахууны зардлаас 1,800.0 мянган төгрөгийн автомашины түрээсийн төлбөр шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ургамал хамгааллын зардлын ангиллыг батлах тухай" А/362 дугаар тушаал болон "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул зөвлөмж хүргэхээр шийдвэрлэлээ.

Өгсөн зөвлөмж:

Зардлын эдийн засгийн ангиллыг баримтлан ажиллах

6. Бүтэц, орон тоотой холбоотой асуудал

6.1 Илрүүлэлт

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/688 дугаар тушаалаар Тэнгис Шишгэдийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны бүтэц, орон тоог 23 байхаар баталсан боловч 24 орон тоотойгоор ажилласан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны "Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаад"-ын бүтэц, орон тооны дээд хязгаар болон сургалт, мэдээллийн төвийн байршлыг шинэчлэн батлах тухай" А/688 дугаар тушаал, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул зөвлөмж хүргэхээр шийдвэрлэлээ.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан бүтэц, орон тоог баримтлан ажиллах.

7. Гэрээ дүгнэхтэй холбоотой асуудал

7.1 Илрүүлэлт

2025 онд 18 иргэн, аж ахуйн нэгжтэй 104.2 сая төгрөгийн шууд худалдан авалтын гэрээг байгуулсан боловч гэрээг дүгнээгүй байна. "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөө бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.Захиалагч худалдан авах ажиллагааг зохион байгуулахад дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ, 48.2.8. "энэ хуульд зааснаар худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах", "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй хангахгүй байгаа тул зөвлөмж хүргэхээр шийдвэрлэлээ.

Өгсөн зөвлөмж:

Худалдах, худалдан авах ажиллагааны гэрээг дүгнэх, тайлагнах.

8.Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудал

8.1 Илрүүлэлт

Худалдах, худалдан авах гэрээнд түлш халаалтын зардлын төлөвлөгөө 10,000.8 мянган төгрөг, гүйцэтгэл 25,096.8 мянган төгрөг 15,096.0 мянган төгрөгөөр гэрээний дүнг хэтрүүлсэн байна. Энэ нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөө бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.11 "гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлбөр тооцоог гүйцэтгэх", санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баримталж ажиллах

9. Байгууллагын дотоод хяналтын үйл ажиллагаатай холбоотой асуудал

9.1 Илрүүлэлт:

“Тэнгис шишгэдийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа” нь байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах байгууллагын дотоод хяналтын нэгжийг байгуулаагүй, дотоод хяналтын журмыг батлаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 1.3 "Энэхүү журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө." 3.1. Энэхүү журмын 1.3-т заасан "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-д өөрөөр заагаагүй бол дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах үүргийг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын захиргааны асуудал хариуцсан нэгж, ажилтан (цаашид "дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан" гэх) гүйцэтгэнэ" гэсэн заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул зөвлөмж хүргэхээр шийдвэрлэлээ.

Өгсөн зөвлөмж:

Хууль тогтоомжид заасны дагуу байгууллагын дотоод хяналтын нэгжийг байгуулан, дотоод хяналтын журмыг боловсруулан, хэрэгжилтийг ханган ажиллах.

10. “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

10.1 Илрүүлэлт:

2025 оны 10 дугаар сарын байдлаар төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал, 2025 оны худалдан авах ажиллагааны тайланг www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлээгүй байна. Энэ нь “Шилэн дансны тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 “төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалт”, 6.3.3 “төсөв хэмнэсэн болон хэтэрсэн бол холбогдох шалтгааныг тайлбарласан тайлбар, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй хангахгүй байгаа тул зөвлөмж хүргэхээр шийдвэрлэлээ.

Өгсөн зөвлөмж:

“Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг ханган, шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөвөөр мэдээлэх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, биелэлтийг төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд 2026 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор мэдээлж, баталгаажуулна уу

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Авлага дутуу тусгасан	1	155.0	1	155.0			1	155.0		
Дүн	1	155.0	1	155.0			1	155.0		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга		Нийт зөрчил		Үүнээс	

Тэнгис шишгэдийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Худалдах, худалдан авах гэрээ байгуулаагүй гүйлгээ хийсэн	1	5,370.0			1	5,370.0						
Анхан шатны баримтын зөрчилтэй гүйлгээ хийсэн	1	2,050.0			1	2,050.0						
Үндэслэлгүй хавсран ажилласны нэмэгдэл олгосон	1	1,026.4			1	1,026.4						
Хоол, унааны хөнгөлөлтийг давхардуулан олгосон	1	2,196.0			1	2,196.0						
Зөвшөөрөлгүй газар конторын барилга барьсан.	1						1					
Шатахуун зарцуулалтын жишиг нормыг баримтлаагүй.	1	11,083.1					1	11,083.1				
Шатахууны орлого, зарлагыг үнэн зөв хөтлөөгүй	1	825.6					1	825.6				
Худалдах, худалдан авах гэрээг дүгнээгүй	1						1					
Өр, авлагын тооцоо нийлж баталгаажуулаагүй	1	6,252.5					1	6,252.5				
Эдийн засгийн ангилал зөрчсөн	1	11,800.0					1	11,800.0				
Гэрээний дүнг хэтрүүлсэн	1	15,096.0					1	15,096.0				
Батлагдсан орон тоог хэтрүүлэн ажилласан	1						1					
Дүн	12	55,699.6			4	10,642.4	8	45,057.2				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, дотоод хяналтын нэгж байгуулаагүй, Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлээгүй	1						1	
	1						1	

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР



Х.ЭНХТУЯА ОГНОО: 2026.02.25